БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 06 өдөр Дугаар А/109 Булган

Ой, хээрт аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг түр хориглох тухай

Монгол улсын Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.18 дахь заалт, Засгийн Газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хуурайшилт ихэсч ой хээрийн түймэр гарч болзошгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан ой, хээрт аялах, ан агнах, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг 2019 оны 03-р сарын 10-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар хориглосугай.
2. Түймрийн I–II зэрэглэл болон буурсан үед галын дүгнэлт, гал гаргахгүй байх гэрээ байгуулан, дээрх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг зөвшөөрсүгэй.
3. Хуурайшилтын үед сум орон нутагтаа байнгын жижүүр ажиллуулж, аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тогтмол мэдээлж байхыг сум дундын Ойн анги, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.
4. Хуурайшилтын зэрэглэлийг өдөр бүр гаргаж, холбогдох газар, сумын Засаг даргын Тамгын газарт мэдээлж байхыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв /С.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Батболд/, Онцгой байдлын газар /Ш.Баасандорж/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/, сум дундын Ойн анги, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА З.БАТЗОРИГ

D:\ЗДТГ,ХОХБТХ\Захирамж

20190139